



# Хууль Зүйн Яам

## Эрх Зүйн Мэдэгдэл

ТҮР ХОРИОНД ОРСОН ЭТГЭЭДЭД ГАРДУУЛАХ  
АЛАН ХЯДЛАГА БУЮУ ТЕРРОРИЗМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (ЭРҮҮГИЙН БАЙЦААН  
ШИЙТГЭХ ХУУЛИЙН ЗҮЙЛ 63-1, 706-73, 11°, 706-88 БА 706-88-1 ЗҮЙЛ)

**Доорх мэдээллүүдийг таны ойлгох хэл дээр бичиж танд өгсөн байх шаардлагатай.  
Та энэ баримт бичгийг хоригдох хугацаандаа хадгалах эрхтэй.**

Таныг ямарваа нэгэн алан хядлага буюу терроризмийн гэмт хэрэг эсвэл зөрчил үйлдсэн эсвэл үйлдэхийг завдсан болох хэрэгт сэжиглэх ганц эсвэл хэд хэдэн шалтгаан байгаа учраас таныг түр хорионд оруулж саатуулсан тухай танд мэдээлсэн.

Та 24 цагийн түр хорионы үеэр таны үйлдсэн хэргийн дагуу таныг байцаах болно.

Та өөрийнхөө түр хоригдох болсон зөрчлийн утга шинж, огноо ба байрлалыг мэдэх бүрэн эрхтэй болон өөрийг тань түр хорих болсон тодорхой шалтгаануудыг мэдэх эрхтэй.

Энэ хугацааны эцэст Улсын прокурор эсвэл шүүгч нар таны түр хорих хугацааг цаашид дахин 24 цагаар үргэлжлүүлэн сунгах эсэхийг шийдэх эрхтэй. Шүүхийн байгууллага нь таныг шүүхэд хүрэлцэн ирэх зөвшөөрлийг олгоно.

Онцгой байдлаар хэрвээ байцаалтаар шаардсан эсвэл зааварчилгаагаар шаардсан тохиолдолд түр хориог нэмэлт 24 цагаар хоёр удаа сунгах эрхтэй, хорио тус бүр 24 цагийн хугацаатай, үүнийг эрх чөлөө олгох ба түр хорио шийдэгч шүүгч эсвэл анхан шатны шүүгч шийднэ.

Гэсэн хэдий ч мөрдөн байцаалтын урьдчилсан таамаглах боломжтой хугацааг 48 цагийн дотор батлан гүйцэтгэгдэх нь батлагдсан тохиолдолд эрх чөлөө олгох ба түр хорионд оруулах эсэхийг шийдэгч шүүгч нь Улсын прокурорын хүсэлтээр эсвэл анхан шатны шүүгч нь түр хориог зөвхөн ганц удаа 48 цагаар сунгахыг шийдэж болно.

Хэрвээ мөрдөн байцаалт нь эсвэл түр хорионы анхдагч хэсгүүд Франц улсад эсвэл гадаадын аль нэгэн улсад олон улсын хамтран ажиллагаа шаардсан алан хядлага эсвэл терроризмийн ноцтой үйлдлийн эрсдэлтэй байна гэж үзсэн тохиолдолд эрх чөлөө ба түр хорио шийдэгч шүүгч түр хорионы хугацааг 24 цагаас илүү хугацаагаар нэмж сунгах шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

Энэ хорих хугацааны эцэст Улсын прокурорын эсвэл шүүгчийн шийдвэрийн дагуу таны хэргийг захиргааны шүүхэд хэрэг гарган шийдвэрлүүлэх боломжтой эсвэл таныг суллан чөлөөлж болно. Эхний тохиолдолд та зохих өдөр шүүх хуралд орж шүүгчээр хэргээ шийдүүлнэ. Хэрвээ хууль зүйн байгууллагад зохих байдлаар тоногдсон хорих байр байдаг бол мөн таны түр хорио 72 цагаас хэтрэхгүй хугацаатай байвал та түр хорионы эцсээс 20 цагаас хэтрэлгүй хугацаанд дараагийн өдөр шүүх хуралд оролцох болно. Хэрвээ таны түр хорио 72 цагаас илүү хугацаатай бол таны шүүх хуралд орж хэргээ шүүгчээр шийдүүлэх нь түр хорио дуусах өдөрт ноогдоно.

**Үүнээс гадна та дор дурдсан эрхтэй:**

### Ойрын хүмүүст мэдээлэл хүргэх

Та өөрийн түр хорионд орсон байдлыг харгалзаж хамтран амьдрагчдаа эсвэл эцэг эхийнхээ хэн нэгийг эсвэл өөрийн ах эсвэл эгч рүү шууд утсаар утасдан мэдээллийг хүргэх, түүнд түр хорионд орсноо мэдэгдэж болно.

Та мөн өөрийн ажил олгогчдоо энэ мэдээг хүргэж болно.

Хэрвээ та гадаад улсын иргэн бол та өөрийн улсын консулын газарт үүний тухай мэдээлж болно.

Даван гарах боломжгүй байдлуудаас бусад тохиолдлуудад шүүгчид өргөдлөө гаргасан хугацаанаас 3 цагаас хэтрэхгүй хугацаанд яаралтай уг хэрэгт оролцоно.

Хэрвээ та хууль зүйн аливаа нэгэн хамгаалалттай бол таны асран хамгаалагч, таны куратор эсвэл таны төлөөлөгч нарт үүний тухай мэдээллэх болно.

Улсын прокурор эсвэл анхан шатны шүүгч нь цуглуулах зайлшгүй шаардлагатай эсвэл амь насанд, эрх чөлөөнд эсвэл хэн нэгний бие махбодид халдсан нотолгоо цуглуулахад шаардлагатай бол саналуудыг хойшлуулах эсвэл үүнийг хүргэх боломжгүй зэргийг шийдэх эрхтэй.

Хэрвээ таны түр хорио 48 цагаас илүү хугацаатай сунгасан тохиолдолд, эрх чөлөө ба түр хорио олгох шүүгч (эсвэл анхан шатны шүүгч) нар таны ойр дотны хүмүүс ба таны ажил олгогчийн саналын тайланг хадгалах боломжтой.

Хэрвээ та өөрийн ойрын хэн нэгэнд мэдэгдэл хүргэх эрхгүй болсон бөгөөд таны түр хорионы хугацаа 96-р цагаас тоолон илүү хугацаагаар сунгагдах болсон тохиолдолд та өөрийн энэ хүсэлтийг 96-р цагаас эхлэн дахин давтан гаргаж болно.

### **Хэн нэгэнтэй холбоо барих**

Та өөрийн түр хорионд орсон тухай мэдэгдэх шаардлагатай хэн нэгэнтэй бичгээр, утсаар эсвэл ярилцлага хийж холбогдон харилцаж болно

Шүүхийн цагдааны албан хаагч нь хэрвээ уг хүсэлт таны хоригдох болсон хэргийн шалтгаануудтай тохирохгүй байх эсвэл үүнээс үүдэж аливаа нэгэн зөрчил үүсэх эрсдэл бий гэж үзвэл таны хүсэлтийг хүлээн авахгүй байж болно. Тэр түүний эсвэл өөр нэгэн албан хаагчийн хяналтан дор 30 минутаас илүүгүй үргэлжлэх тус харилцааны огноо, хугацаа, байдлуудыг тодорхойлно.

Хэрвээ таны түр хорио 48-аас илүү хугацаагаар үргэлжлэх тохиолдолд, шүүхийн цагдааны хэлтэсийн албан хаагч таны консулын газрын төлөөллүүдтэй холбогдох хүсэлтэд татгалзах эрхгүй.

### **Эмчийн үзлэгт хамрах**

Хоригдох хугацааны эхнээс эхлэн та түр хориог сунгасны улмаас дахин давтан эмчийн үзлэгт хамрах хүсэлт гаргаж болно. Зөвшөөрсөн нэмэлт сунгалт бүрт та зайлшгүй эмчийн үзлэгт хамрагдах бөгөөд та дахин эмчийн үзлэгт хамрагдах хүсэлт гэргэх эрхээ эдлэх боломжтой болно.

Хэрвээ та хууль зүйн хамгаалалттай нэгэн бол таны асран хүмүүжүүлэгч, таны куратор эсвэл таны тусгай төлөөлөгч нар таныг эмчийн үзлэгт хамруулахыг хүсэх эрхтэй.

### **Мэдэгдэл хийх, асуултанд хариулах эсвэл үг хэлэхгүй байх**

Та өөрийн биеийн байцаалтаас татгалзсан бол, та шүүх хурлуудын үед та доорх эрхийг эдэлнэ:

- мэдэгдэл гаргах,
- таниас асуусан асуултад хариулах
- үг хэлэхгүй байх.

### **Өмгөөлөгчийн туслалцаа авах**

#### **Өмгөөлөгчийн сонголт**

Түр хорио эхлэснээс эхлэн шүүх хурлын аливаа нэгэн мөч хүртэл түр хорих хугацаа сунгасан тохиолдолд сунгалтын эхэнд та өөрийн сонголтоор өмгөөлөгчийн туслалцаа нэхэх эрхтэй. Хэрвээ та өмгөөлөгч сонгох боломжгүй эсвэл таны өмгөөлөгчтэй холбоо барих боломжгүй тохиолдолд та бичиг хэргийн газраас томилсон өмгөөлөгчийн туслалцаа авахыг хүсэж болно.

Хэрвээ та хууль зүйн хамгаалалттай нэгэн бол таны асран хамгаалагч, таны куратор эсвэл таны тусгай төлөөлөгч нар таны өмгөөлөгчийг томилох эсвэл зохих төлөөлөөс томилохоор хүсэлт гаргаж болно.

Таныг өмгөөлөх өмгөөлөгчийг тантай холбоо барьсан хүн мөн адил томилж болно: энэ тохиолдолд та өмгөөлөгч томилсоныг баталгаажуулах шаардлагатай.

#### **Өмгөөлөгчийн туслалцаа**

Томилогдсон өмгөөлөгч нь тантай 30 минутын хугацаатай ярилцаж болно. Хорих хугацааг сунгасан тохиолдолд энэ сунгалтын эхэнд та өөрийнхөө өмгөөлөгчтэй дахин ярилцах хүсэлтийг дахин гаргаж болно.

Үүний зэрэгцээгээр тэр, хэрвээ таныг хүсэлт гаргасан тохиолдолд таны маргаан, шүүх хуралд оролцох, таны үйлдсэн үйлдлүүдийг давтах, үйлдлүүдийг тодорхойлох хэрэгт оролцож болно.

### **Оролцооны хугацаа**

Таны нэн даруй ба яаралтай оролцоо шаардсан мөрдөн байцаалт дээр тулгуурлаж, Улсын прокурор нь бичгээр үйлдсэн шийдвэрээр таны шүүх хурлыг таны өмгөөлөгчийн хүрэлцэн ирэх 2 цагийн хугацааг өнгөрүүлэхгүйгээр хүлээлтгүй хурлыг эхлүүлэх эрхтэй.

Хэрвээ маш чухал шалтгаан байвал Улсын прокурорын шийдвэрээр, эрх чөлөө ба түр хорионы шүүгчийн

шийдвэрээр, эсвэл анхан шатны шүүгчийн шийдвэрийг харгалзан хамгийн дээд 48 цагийн хугацаанд өмгөөлөгчийн оролцоог хойшлуулж болно.

### **Хэлмэрчийн туслалцаа авах**

Хэрвээ та франц хэлээр ярьдаггүй ба ойлгодоггүй бол та үнэ төлбөргүй шүүх хурлуудынхаа үеэр болон өмгөөлөгчтэйгөө харилцахаар хэлмэрч авах эрхтэй.

### **Түр хорионы төгсгөлд хүргэх өөрийн ажиглалтуудыг танилцуулах**

Та Улсын прокурорт эсвэл анхан шатны шүүгчид шүүгч таны түр хорионы хугацааг сунгах шийдвэр гаргаж байхад, та өөрийн хүсэлт ажиглалтыг танилцуулан өргөж болно.

### **Хэргийнхээ зарим хэсгүүдтэй танилцах**

Таны хүсэлтээр эсвэл таны өмгөөлөгчийн хүсэлтээр та өөрийн түр хориог сунгахын өмнө доорх байдлуудтай танилцах эрхтэй:

- таныг түр хорионд оруулах тухай протоколын мэдэгдэл;
- таныг үзсэн эмчийн гаргасан эрүүл мэндийн гэрчилгээ эсвэл гэрчилгээнүүдтэй танилцах,
- шүүх хурлуудын протоколуудтай танилцах эрхтэй.

### **Улсын прокурорт танилцуулах**

Түр хорио дууссаны дараа нэг жилийн хугацаанд Улсын прокурорт баталгаатай захидлаар эсвэл нотариатын нотолгоотой итгэмжлэлээр танилцуулга боловсруулах зорилгоор өөрийн хавтаст хэрэгтэй танилцах тухай мэдэгдэл гаргаж болно.